



ХҮН КАПИТАЛ НЬ ХӨГЖЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ МӨН

МУБИС - ийн докторант С.Нарандулам

Хүн капитал (human capital, brain capital, human) гэдэг ойлголтын тухай шинжлэх ухааны салбар бүрт өөр өөрийн судалгааны чиглэлтэй холбон авч үзэж байна. Тухайлбал, түүхийн шинжлэх ухаанд, хүн бол түүх, хуульзүйн шинжлэх ухаанд, хүн бол хуулийн этгээд, сурган хүмүүжүүлэх ухаанд, хүн бол хүмүүжигч, хүмүүжүүлэгч, эдийн засгийн шинжлэх ухаанд, хүн бол баялаг бүтээгч буюу үйлдвэрлэлийн хүчин зүйл мөн гэж авч үздэг. Харин бид, боловсрол судлалын шинжлэх ухааны болон эдийн засгийн шинжлэх ухааны хавсарсан судалгаа шинжилгээний үр дүнд сонгосон сэдвийн хүрээнд, хүн капитал (human capital, brain capital, human) нь хөгжлийн хүчин зүйл гэж авч үзэж байна. Хүн хооллох, амрах зэрэг биологийн хэрэгцээгээ хангах талаараа бусад адгуусан амьтан лугаа адил байдаг. Хүний энэ байдал нь түүнийг байгалийн амьтан болохыг илтгэн харуулна. Адгуусан амьтан хоол ундаа байгалиас бэлнээр нь олж хэрэгцээгээ хангаж байдаг тул бусад адгуусан амьтантайгаа хорших, хамтрах шаардлагагүй байдаг. Харин хүн бол эрэлт хэрэгцээгээ хангахын тулд хоол, хувцас, орон гэрээ бүтээж бий болгохын тулд бусад хүмүүстэйгээ хамтран нэгдэх зайлшгүй шаардлагатай болдог. Хүний энэ байдал нь түүнийг нийгмийн амьтан болохыг илтгэн харуулна.

Хүн байгалийг өөрчилж сурахын зэрэгцээ оюун ухаанаа хөгжүүлж үүний дүнд өөрөө боловсорч хөгжиж иржээ. Хүн баялгийг хамтын хүчээр хөгжих явцдаа байгалийн хуулийг танин мэдэж, түүнийг ашиглах үр чадвар нь улам хөгжсөнөөр шинжлэх ухаан технологийн асар их ололт амжилтыг бүтээж иржээ. Эдийн засгийн шинжлэх ухаанд “Хүн бол хөдөлмөрийн үйл явцдаа бусад хүмүүстэй зайлшгүй холбоо харилцаанд орж байдаг хамтын ухамсарт амьдрал бүхий нийгмийн амьтан болно” гэж авч үздэг. Хүн хэрэгцээгээ хангах шинэ баялаг бүтээхдээ, нийгэм хэмээх байнгын хувьсал өөрчлөлтийн орчинд, чанарын илүү өндөр хэлбэрт нэгдэж байдаг болно.

Хүний үйл ажиллагааны бие даасан байдал, эрх чөлөө нь туйлын бус харьцангуй шинж чанартай. Нийгмийн шинжлэх ухаан нь хүнд хамааралтай бүхий л асуудлыг судлах биш харин ертөнцийн байнгын хувьсан өөрчлөгдөх хөдөлгөөний зөвхөн нийгмийн (социал) шинж чанарыг авч үзэж судалгаа шинжилгээ хийдэг. Тухайлбал, хүний бие бялдар, химийн нэгдлүүдийн цогц гэх мэт биологийн чиглэлээр судлахгүй, харин зөвхөн нийгмийн харилцаа болон нийгэм дэх хүнийг амьдарч буй орчинтой нь уялдуулан судалгаа шинжилгээ хийж байгаагаар онцлогтой юм. Ийнхүү шинжлэл судлалын цар хүрээ нь нийгмийн бодит бүтэц ба практик шаардлагыг илэрхийлж байгаа тухайн шинжлэх ухааны хэм хэмжээнд судалгаа шинжилгээ хэрэгжиж байдаг.

Хүний боловсрол, мэдлэгт оруулсан хөрөнгө оруулалт нь “оюуны капитал” болдог (brain capital) зүй тогтлыг онолын хувьд үндэслэн, төрийн бодлогод тусгахад хүн капиталын үзэл баримтлалын ач холбогдол оршино. Хүн капиталын үзэл баримтлал нь боловсрол сургалтын явцад хүний ирээдүйд олох орлогыг нэмэгдүүлэх үндэс

бүрддэгт тулгуурласан байдаг. Хүн капитал гэдэг ойлголт нь боловсролд зарцуулсан зардал нь хүнд оруулсан хөрөнгө оруулалт бөгөөд тэр нь хүний ирээдүйн орлогын эх үүсвэр болж байх зүй тогтол юм. Хөрөнгө буюу капитал хэмээх ойлголт юуны өмнө бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон үйлчилгээнд ашиглагдаж, хүний бүтээсэн үйлдвэрлэлийн хэрэгсэл ба баялаг бүтээж, түүнийгээ эцсийн хэрэглээнд хүргэж буй газар, барилга, байгууламж, тоног төхөөрөмж гэх мэт хөрөнгө хамаарагдана. Үйлдвэрлэлийн явц, түүний хөрөнгийн хуримтлалыг хөрөнгө оруулалт гэж авч үзнэ. Ийнхүү эд зүйлсийн тодорхой хэлбэрийг капитал гэж нэрлэх бөгөөд капитал нь хөрөнгийн хуримтлал болохын хувьд эргээд баялаг бүтээх эх үүсвэр болдог учраас газар, хөдөлмөр, үйлдвэрлэлийн хэрэгсэл гэсэн ойлголтуудыг үйлдвэрлэлийн хүчин зүйлс гэж эдийн засгийн шинжлэх ухаанд авч үздэг. Хүн төрөлхтний нийгмийн хөгжлийн эхний үеийн урт удаан хугацааны үе шатуудад капитал гэсэн ойлголт байгаагүй байна. Нийгмийн хөгжлийн түүхэн нөхцөлд үйлдвэрлэлийн хэрэгсэл нь капитал гэж нэрлэгддэг болжээ. Газар нь өсгөж арвижуулах боломжгүй хамгийн хязгаарлагдмал нөөц бөгөөд хүн ашиглаж хэрэглэх болох боломжтой учраас газар дээр оршин байгаа гол, мөрөн, далай зэрэг усны ай сав, далай доторх загас, амьтан, далайн ургамал, нефть, хий, эрдэс баялаг зэрэг хязгаарлагдмал нөөцийг эдийн засгийн шинжлэх ухаанд газар гэсэн ойлголтод хамааруулж авч үздэг. Хөдөлмөр гэдэг нь байгалийн хязгаарлагдмал нөөцийг ашиглан хүний хэрэгцээг хангахын тулд зохицуулан өөрчилж буй хүний тодорхой зорилго, чиглэл бүхий үйл ажиллагаа болно.

“Хөгжлийн төвд хүн” гэсэн үзэл баримтлал бүхий тогтвортой хөгжлийн зарчмаар бүхий л асуудалд хандах хандлага тодорхойлох болсон энэ үед тухайн үед олж авсан мэдлэг эцсийн зорилго бус харин хүнийг ирээдүйд өөрийгөө хөгжүүлж амьдрахын нөлөөлөх хүчин зүйл болох учиртай. Боловсролын ач холбогдол нь хүн эзэмшсэн боловсролдоо сэтгэл хангалуун байж, чинээлэг амьдрах, нийгэмд хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлээд, үр хүүхдийнхээ ирээдүйн жаргалтай амьдралын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж чаддаг байх тухай болно. Улс орнуудын төр засгаас хүн амын аж амьдралын баталгаатай нөхцөлийг төрийн бодлогоор хангах үүрэг хариуцлагаа хууль эрхзүйн баталгаат орчинд хэрэгжүүлдэг практик, ололт, амжилтыг дэлхийн бусад орны засгийн газрууд өөрийн орны онцлогт тулгуурлан хөгжүүлсээр байна.

Нийгэм эдийн засгийн салбарын бүтцэд боловсролын салбар нь тэргүүлэх үүрэгтэй байдаг учраас эдийн засгийн шинжлэх ухааны онолын хувьд хувь хүний өөрийгөө хөгжүүлэх зорилго бүхий хөрөнгө оруулалт хийж боловсрол эзэмшиж өндөр мэдлэг үр чадвартай иргэн болж хөгжих тухайд, хүн хөгжил, хүн судлал, хүн капитал, хүн хөрөнгө оруулалт, орлого хуваарилалт, улс орны хөгжлийн тулгуур нь боловсролтой хүн болох тухай эдгээр ойлголтын талаар номлож ирсэн манай тооллын өмнөх үеэс өнөө хүртэлх



үеийн агуу их сэтгэгчид, суут хүмүүс, эрдэмтдийн онол, сургаал, үзэл баримтлалыг тоймлон авч үзье.

Эртний Грекийн нэрт сэтгэгч Ксенефонт (МЭӨ 430-354 он) “Орон гэрийн байгуулал” бүтээлдээ, эд хөрөнгө, баялаг бүтээх хууль буюу “Oikos-nomia” гэдэг Грек нэр томъёог анх удаа гаргаж ирсэн байна. (“Oikos” эд аж ахуй, нөөц баялаг, “Nomia” хууль эрхзүй, хэм хэмжээ, норм гэсэн утгатай болно.) Эртний Грекийн хүн амыг, өрх гэрийн хүрээнд өрхийн гишүүн бүрийг хөдөлмөрч ажилсаг болж хүмүүжиж, эд зүйлсийг дагнах, хорших мэргэшсэн ур ухаанаар бүтээх мэдлэг ур чадвартай болгоход анхаарах хэрэгтэй, ингэснээр хөдөлмөрийн хуваарийг хот, хөдөөд хөгжүүлэх нь баялаг бүтээх чухал нөхцөл болно гэж сургажээ. Энэ бол тухайн үедээ гар урлалын бүтээл, газар тариалангийн салбарт тариа тарих, зэрлэг амьтныг гаршуулан тэжээх замаар ашиг шимийг нь өрх гэртээ хэрэглээ болгох, мал маллах арга ухаан зэргээр төрөлжсөн, тусгайлсан, дагнасан чадвартай болгох, мэргэшүүлэх тухай анхны үзэл санааг тэрээр гаргаж байсан бөгөөд хүнийг хөдөлмөрч, баялаг бүтээх чадвартай болгосноор улс орноо хөгжүүлэх тухай сургажээ. Ксенефонтын энэ сургаал нь хүн хөгжлийн түвшин = боловсролын хэм хэмжээ + хүний бүтээсэн баягийн хэм хэмжээ гэж томъёолж болох бөгөөд хүний амьдралынхаа туршид бүтээсэн баягийн хэмжээ нь түүний мэдлэг ур чадвараас шууд хамааралтай гэсэн утга агуулгатай болно.

Английн эрдэмтэн А.Маршалл, Эртний Грекийн “Oikos-nomia” гэдэг нэр томъёог нь “Economics” гэсэн англи нэр томъёо болгосон юм. Эртний Грекийн агуу сэтгэгч Платон (МЭӨ 428-347 он) Улс төрийн бодлого хийгээд төр улс бүтээлдээ тухайн үеийн төр засгийг удирдаж байгаа хүмүүс бол төрөлхийн онцгой оюун ухаан сайтай, авьяаслаг чадвартай учраас төр засгаас дэмжиж байх тухай сургасан нь тухайн үеийн нийгмийн харилцаанд төрийн алба хаадаг хүмүүсийг хамгийн шилдэг ухаантай, мэдлэгтэй, улс орныхоо үнэт зүйл гэж хүндэтгэн өргөмжилж, төрийн байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх тухай анхны үзэл санааг гаргаж байжээ.

Эртний Грекийн агуу сэтгэгч Аристотель (МЭӨ 384-322 он) Афин хотод Гүн ухааны сургуулийг анх үүсгэн байгуулж, шинжлэх ухааны судалгаа шинжилгээ хийж, хүн амыг сурган хүмүүжүүлэх үйл хэргийг эрхлэн, анхны боловсрол, судалгааны бие даасан салбарыг байгуулж байжээ. Аристотель “Улс төрийн бодлого” бүтээлдээ хувь хүн хөгжих үндэс нь эрх чөлөөтэй орчин байх тухай сургаснаар төр засгаас хүний эрхийн тухай, хүн чөлөөтэй, нээлттэй орчинд л сайн боловсрол эзэмших орчныг дэмжих тухай анхны үзэл санааг гаргасан байна. Аристотелийн сургаал номнолын агуулга нь “боловсролтой хүн амын тоо = бичиг мэдэгч хүний тоо + сургуульд суралцаж буй сурагчдын тоо” гэж томъёолж болох бөгөөд боловсрол эзэмших орчны ач холбогдлыг эдийн засгийн үүднээс эрэлт нэмэгдэхийн хэрээр нийлүүлэлтийн боломж нь үйлчилгээний чанараар тодорхойлогдох тухай болно. Өнөө үед олон улсын хэмжээнд энэ томъёоллоор нийт хүн амын дунд боловсролтой хүн амын тоо хэмжээг тодорхойлох аргачлал болгон ашигласаар байна.

Чингис хаан (1162-1227)-ы алдарт сургаал нь:

Алд бие мину алжааваас алжаатугай!

Ахуй төр мину бүү алдартугай!

Бүтэн бие мину зовбоос зөвтүгэй!

Бүрэн улс мину бүү алдартугай! гэж үеийн үед Монгол улсаа хөгжүүлэхэд хувь хүний гүйцэтгэх үүрэг, хариуцлагын тухайд, хувь хүн өөрийн ашиг сонирхлоос төр нийгмийн

ашиг сонирхлыг илүү дээдлэн хүндэтгэх үзэл баримтлалтай байхыг ард түмэндээ захиж үлдээсэн болно. Чингис хаан, төр улсаа хөгжүүлэхийн төлөө тэмцэл нь хувь хүний өөрийгөө хөгжүүлэхийн төлөө тэмцэл болох тухай сургажээ.

Италийн агуу их сэтгэгч, Ромын сүмийн хамба лам Фома Аквинский (1225-1275он) “Шашны сургаалийн нийлбэр” бүтээлдээ төр засгаас хувь хүний оюуны хөдөлмөрийг дэмжиж, хамгаалж байх, хүн амын оюуны хөдөлмөрийн үр дүнд улс орон хөгжих тухай сургасан байдаг. Тэрээр хүний хөгжил = улсын хөгжил болон “Иргэн баян бол улс баян байна” гэж авч үзсэн нь хүний оюун ухааны хөгжил нь улс орноо хөгжүүлэх ухаантай ард түмэнтэйг гэрчлэх болно, хүний оюун ухааныг хөгжүүлэхэд төр засгаас дэмжих тухай номлож байжээ. Тухайн үедээ сүм хийдэд ирдэг хүн ардад сүмийн лам нар нь аз жаргалтай амьдрах утга учрыг ярьж тайлбарлаж байсан учир ард түмний дунд хамгийн нэр хүндтэй хүмүүс нь лам нар байжээ.

Дундад зууны үеийн Монголын нэрт сэтгэгч, Сэцэн хан аймгийн хошууны засаг ноён Бат – Очирын Тогтохтөр ван (1787-1887он) “Бичиг үсгийн сургууль”-ийг байгуулж, монгол хэл, манж хэл зааж сургаж байсан ба шавь нар нь хожим бүгд засаг захиргааны түшмэлийн албан тушаалд ажиллаж байжээ. То ван хэмээн алдаршсан тэрбээр “Хэвэй вангийн аж төрөх үйлийг заасан сургаал болой” гэдэг бүтээлдээ, хүн бүр баялаг бүтээгч, хөдөлмөрч ажилсаг болохын тулд бодит амьдралаас суралцах, хүн бүр аливаа хэрэглээндээ арвилан хэмнэж хандаж байвал сайхан амьдрах боломжийг бүрдүүлэх тухай, хүн ам нь хөдөлмөрч болж төлөвшиж чадвал улс орон хөгжинө гэж сургажээ. Ту хайлбал,

Ногоо нялх боловч

Тэнгэрийн хураар тэжээвэл удахгүй ургах

Хүн бага ч бол

Сургаал үгээр тодорвол

Оюуны лянхуа нээх

Хичээлтэй хүн нь эс халдвас эрдэм сурах

Хичээл үгүй хүнийг зэмлэвээс

Бахиран муу санах

Арга ухаан сайт ард

Алс хойтын хэргийг урьдчилан бодогч зэргээр өрх гэрийн орчинд хүүхдийг багаас нь ажилсаг хөдөлмөрч болгон зөв хүмүүжүүлэх нь аав ээждээ ачийг нь хариулах ухаантай хүн болж төлөвших, алс хэтийн ухаалаг үзэл бодолтой хүн болох тухай сургаж байжээ. Тогтохтөр ван Монгол хүн бүр хязгаарлагдмал нөөцөөр хязгааргүй хэрэгцээгээ хангахдаа байнга арвилан хэмнэх үзэл бодлоор ханддаг болж хүмүүжих, өрх гэрийн болон мал аж ахуйн бүхий л ажлыг сайн хийж чадах мэдлэг ур чадварыг үеийн үед эзэмшиж байх тухай сургажээ.

14-р зууны үеийн Арабын нэрт философич Ибн Халдун (1332-1406) тухайн үеийн Арабын нийгмийн харилцааны бодит байдалд өөрийн гэсэн үнэлэлт дүгнэлт өгч, хүн баялаг бүтээж, олж буй цалин хөлс нь өдөр тутмын хэрэглээнд болон нөөц буюу хадгаламж гэсэн хоёр хэсэгт хуваах бөгөөд нөөцлөн хадгалж байгаа мөнгө нь ирээдүйд хүний сайхан амьдрах эх үүсвэр нь болж аливаа эрсдлээс хамгаалж тайван амьдрах боломж олгох, өөрийгөө хөгжүүлэхэд энэ мөнгөө зориулах, өөрөөр хэлбэл, хүн өөртөө хөрөнгө оруулалт хийснээр шинэ мэдлэг ур чадвар эзэмшиж байж л улам хөгжих тухай, хүний амьдрал нь материаллаг, хөрөнгө мөнгөн дээр суурилан хөгжих тухай шинжлэх ухаанч байр сууринаас тайлбарлахыг хичээсэн байна.



Италийн философич Томас Кампанелла (1568 –1639) “Наран хот” гэдэг бүтээлдээ, өрх гэр нь хувийн өмчтэй, ялангуяа өөрийн гэсэн газартай бол хөдөлмөр хийж, байнгын орлоготой байж сайхан амьдрах тухай, хүн сайхан амьдрахын утга учрын тухай суралцах хэрэгтэй, үүний тулд хүнд эдийн засгийн бааз суурь зайлшгүй чухал болох тухай, мөнгөн орлогын үр дүнд хүн, өрх гэр хэрхэн хөгжих тухай, хэрэв ийм бодлогоор хүн амьдралаа хөгжүүлж чадвал түүний амьдрал нь үргэлж нартай дулаахан өдөр шиг сайхан амьдрах тухай сургажээ.

Английн улс төрч Вильям Петти (1623 –1687) “Мэргэдийн үг” гэдэг бүтээлдээ, хөдөлмөр бол баялгийн эцэг, газар бол баялгийн эх мөн гэсэн алдарт сургаалаа бичсэн байна. Хүн баялгийг бүтээх үндэс нь материаллаг хөрөнгө, мөнгөн хөрөнгөнд суурилах тухай мөн ажил хийх мэдлэг чадварыг суралцаж эзэмшсэн бол баялаг бүтээснээрээ илүү их орлого олж, өөрийгөө сайхан амьдрах боломжтой болгож чадна, энэ учир хүн бүр чадвартай боловсролтой болохын тулд хичээх хэрэгтэй гэж сургажээ.

Францын философич Франсуа Кене (1694 -1774) “Капитал” гэдэг нэртөмьёо, ойлголтыг эдийн засгийн шинжлэх ухааны салбарт анх удаа томьёолсон хүн бөгөөд, капитал гэдэг нь үл хөдлөх хөрөнгө, газар, үндсэн хөрөнгө, хүний бүтээсэн үнэт зүйл болох баялаг гэсэн утга санаа бүхий хүний урт удаан хугацааны амьдралдаа байнгын орлого олж байх эх сурвалж нь капитал болох тухай томьёолсон байдаг. Хүн бүр баялгийг бүтээж, арвижуулж, хадгаламж болгох зэргээр суралцаж мэдлэг чадвартай болбол төр улс хөгжинө гэж сургажээ.

Шотландын нэрт эдийн засагч Адам Смит (1723–1790) “Ард түмний баялгийн уг чанар хийгээд шалтгааны судлал” алдарт бүтээлдээ, хүний хөдөлмөр бол хязгааргүй их баялаг бүтээх эх сурвалж мөн, хүний хөдөлмөр бол мөнгө мөн, хувь хүн баян бол улс баян, ард түмний баялаг бүтээх үйл явц нь үл үзэгдэх гарын зохицуулалт буюу нээлттэй, чөлөөтэй зах зээлийн эдийн засгийн тэнцвэрт үнээр зохицуулагдаж байх орчин бөгөөд харин төрөөс эдийн засагт оролцохгүй байх, ингэснээр нийгэм нээлттэй хөгжих тухай гэсэн үзэл баримтлал бүхий онолын томьёоллоо боловсруулан гаргажээ. А.Смит

хувь хүний нээлттэй, чөлөөтэй орчинд хэрэгцээгээ хангах зорилго бүхий эрэлтийг тодорхойлоход хамаарах хүчин зүйлсийн хоорондын харилцан уялдаа холбоог эрэлтийн ерөнхий функц нь:

$$Q_{Di} = F (P_1, P_2 \dots P_n, I, W, T, E, S) \quad (1)$$

Үр дагавар
Энд:
 Q_{Di} = Эрэлтийн функц -нэгж хугацаан дахь эрэлтийн хэмжээ

F = шаардагдаж буй эрэлтийг хангах үнэ -хөрөнгийн зарцуулах нийт хэмжээ

P_1 = нэн тэргүүнд шаардагдаж буй эрэлтийг хангах үнэ, хөрөнгийн зарцуулах хэмжээ

$P_2 \dots P_n$ = нэн тэргүүнд шаардагдаж буй эрэлтийг хангахад зайлшгүй хэрэгтэй бусад товар, үйлчилгээний үнэ, хөрөнгийн зарцуулах нийт хэмжээ

I = хувь хүний орлогын хэмжээ

W = хувь хүний амьжиргааны түвшин

T = хувь хүний өнөөгийн эрэлтэд хандах хандлага

E = хувь хүний өөрийнхөө төлөө ирээдүйн эрэлтэд хандах хандлага

S = тухайн эрэлтээр хангагдаж буй цаг хугацааны тэнцвэрт байдал гэж эдийн засгийн онолын хувьд математик томьёоллоор нийгмийн харилцаанд хүн өөртөө хэрэгтэй бүхнээ эрж хайх, хэрэгцээгээ хангах, баялаг бүтээх амьдрах орчин нь нээлттэй, чөлөөтэй байх тухай томьёолсон байна. Энэ томьёоллын үндсэн агуулга, үзэл баримтлал нь тухайлбал, эрэлт болох хүний өөрийнх нь сонирхож байгаа мэргэжлийг, нийлүүлэлт болох дээд боловсролын салбар нь олгож, эрэлтийг нэгдүгээрт хангах боломжийн тухай, дараа нь эрэлтийн хүсэл сонирхлыг хангах нийлүүлэлтийг бий болгох нь улс орны хэтийн хөгжил дэвшилд ач холбогдолтой байх эрэлтийг дээдлэсэн үзэл баримтлал болно. Гэтэл Монгол улсад өнөө үед энэ томьёолол нь эсрэгээр буюу дээд боловсролын мэргэжлийн сургалтад зарим залуучууд эзэмшихийг хүсэлтэй байгаа мэргэжил нь сургалтын хөтөлбөрт байхгүй учраас зөвхөн дээд боловсролтой болохын тулд хүсэл сонирхолгүй ч гэсэн өөр мэргэжил эзэмшихээр суралцаж байгаа нь эхлээд нийлүүлэлтийг, дараа нь эрэлтийг хангах орчин болсон байна.